

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.02.21

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 2 сарын 18

Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	2860.95	+0.247%	+0.407%	+0.385%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.25 хувиар чангарлаа. Мөн дотоодын зах зээлд ханшид нөлөөлөхүйц томоохон үйл явдал болоогүй бөгөөд цаашид олон улсын зах зээлд гэнэтийн үйл явдал үүсэхгүй бол ханш тогтвортой байх хүлээлттэй байна.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн долоо хоногт Монголбанк банкнуудын 92.9 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг биелүүлж зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкууд 30.0 сая ам.долларын своп болон форвард арилжааны санал ирүүлснийг биелүүлээгүй байна.

**Ханшид нөлөөлөхүйц үйл явдал, суурь үзүүлэлтүүд:**

- 2022 оны 1 сард Монгол Улсын гадаад худалдаа 16.9 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарах нь тухайн орны валютын ханш бусад сулрах нөхцөлийг бүрдүүлдэг ч богино хугацааны /хуримтлагдсан бус/ алдагдал нь валютын ханшид шууд нөлөөлөх нөлөөлөл бага байдаг.
- Монголбанк 2022 оны 1 сард 1.6 тонн үнэт метал худалдан авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0.3 тонноор өссөн үзүүлэлт боллоо. Алтны худалдан авалт өсөх нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог.
- Нийлүүлэлтийн доголдол үргэлжилж байгаагаас шалтгаалан инфляцын хүлээлт нэмэгдэх, улмаар инфляцын 2 дахь үеийн нөлөө эрчимжих эрсдэлтэй байгаа тул Монголбанкнаас мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж, бодлогын хүүг 0.5 нэгж хувиар өсгөсөн. Түүнчлэн, гадаад зах зээлийн суурь хүү өсөх төлөвтэй байгаа нь бодлогын хүүг өсгөх нөхцөлийг бий болгож байна. Хүү өсөх тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлдэг.


Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гадаад валютын албан нөөц:

Монгол Улсын гадаад валютын албан нөөц сүүлийн 5 жил тасралтгүй өссөөр 2021 оны 4 дүгээр сард түүхэн дээд буюу 4.9 тэрбум ам.долларт хүрсэн. Харин 2021 оны 11 дүгээр сард 4.2 тэрбумд хүрч бага зэрэг буурсан ч 12 дугаар сараас дахин өсөж 4.4 тэрбум ам.долларт хүрлээ. ГВАН 4.4 тэрбум ам.доллар байгаа нь импортын 7 сарын санхүүжилтийг хангахуйц үзүүлэлт бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшнээс 7.1 хувиар өндөр байна. ГВАН өндөр байх нь төгрөгийн ханш тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.


График 1: Гадаад валютын албан нөөц (сая ам.доллар)



Гадаад худалдаа:

2022 оны 1 сард Монгол Улсын гадаад худалдаа 16.9 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Нийт бараа эргэлт 1.1 тэрбум ам.доллар байгаагаас экспорт 0.54 тэрбум ам.доллар, импорт 0.56 тэрбум ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарах нь тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг сулрах нөхцөлийг бүрдүүлдэг.

График 2: Гадаад худалдаа (сая ам.доллар)



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 2-р сарын 18

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	96.0856	0.00%	0.60%	6.33%
EURUSD	1.13255	-0.13%	-0.15%	-6.54%
USDCNY	6.32478	-0.65%	-0.44%	-2.09%
USDRUB	77.3071	0.30%	1.65%	4.54%
USDJPY	115.032	-0.16%	0.59%	9.11%
AUDUSD	0.71808	0.70%	-0.51%	-8.73%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг тогтвортой байлаа. Ханшийн хэлбэлзэлд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- АНУ-ын холбооны нөөцийн сан бодлогын хүүг ойрын хугацаанд өсгөх магадлалтай болсноор ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарах хүлээлтийг үүсгэлээ.
- Нөгөө талаас ОХУ, Украйны дайны тодорхойгүй байдлын улмаас санхүүгийн зах зээл тогтворгүй хэвээр байна. Энэ нь хөрөнгө оруулагчдыг эрсдэл багатай хөрөнгө оруулалтад чиглүүлж, ам.долларын ханш чангарахад нөлөөлж байна.
- Өнгөрсөн долоо хоногийн дундуур үүссэн ОХУ, Украйны асуудлын улмаас DXY индексийн ихэнх хувийг бүрдүүлдэг EUR ханш суларснаар ам.долларын ханшийн индекс өсөх нөхцөлийг бүрдүүлжээ.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 18/Feb/2022 - 17:05:34 GMT, Powered by TradingView.
US Dollar Index, United States, NYSE:DXI, W



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Бэлтгэсэн:



Р.Дарханбаяр

Хөрөнгө оруулалтын шинжээч

Darkhanbayar@golomtcapital.com

+976 9490 4321

Golomt Capital[®]

7012-1530
info@golomtcapital.com
www.golomtcapital.com